

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ТУШААЛ**

2013 оны 3 сарын 6-ны өдөр

Дугаар А- 43

Улаанбаатар хот

“Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-ыг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 14, 15 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулж Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 311 дүгээр тушаалаар баталсан “Төв банкны үнэт цаасны арилжааны журам”, 2010 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 210 дугаар тушаал, 2010 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 232 дугаар тушаал, 2011 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 195 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Мөнгөний бодлого, судалгааны газар (Д.Болдбаатар), Валют, эдийн засгийн газар (Д.Дэлгэрсайхан), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-г тус тус үүрэг болгосугай.

4.“Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-ыг 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЗОЛЖАРГАЛ



## ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, 15 дугаар зүйлд заасны дагуу Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкнаас үнэт цаас гарган арилжаалах үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- 1.2.1 **“Төв банкны үнэт цаас (цаашид ТБҮЦ гэх)”** гэж Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг;
- 1.2.2 **“ТБҮЦ-ны хугацаа”** гэж үнэт цаасыг арилжаалсан өдрөөс буцаан төлөгдөх хүртэлх хугацааг;
- 1.2.3 **“ТБҮЦ-ны хүү”** гэж тухайн үнэт цаасыг хямдруулан худалдаж буй хямдруулалтын хувиар илэрхийлэгдэх хүүг;
- 1.2.4 **“Бодлогын хүү”** гэж хамгийн богино хугацаатай ТБҮЦ-ны хүүг хэлнэ;  
*/Энэ хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А-79 дүгээр тушаалаар өөрчлөн найруулав./*
- 1.2.5 **“ТБҮЦ-ны арилжааны мэдэгдэл”** гэж ТБҮЦ-ны арилжааны нөхцөлийг тусгасан Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан баримт бичгийг;
- 1.2.6 **“Хямдруулсан үнэ”** гэж нэрлэсэн үнээс хямдруулалтын хувиар хямдруулан тооцсон үнийг;
- 1.2.7 **“Нэрлэсэн үнэ”** гэж үнэт цаасны хугацаа дуусах өдөр төлөгдөх дүнг;
- 1.2.8 **“Тогтмол хүүтэй арилжаа”** гэж Монголбанкнаас зарласан тогтмол хүүгээр банкууд худалдан авах үнэт цаасны хэмжээг ирүүлэх арилжааг;
- 1.2.9 **“Хүүгээр өрсөлдөх арилжаа”** гэж Монголбанк худалдах ТБҮЦ-ны хэмжээг зарлаж банкууд хүү болон хэмжээний саналаа ирүүлсэнээр хамгийн бага хүүгийн саналаас эхлэн хуваарилах арилжааг;
- 1.2.10 **“Банк хоорондын цахим арилжааны систем”** гэж Монголбанк болон банкуудын хооронд хийж буй банк хоорондын захын арилжааг гүйцэтгэх цахим системийг тус тус хэлнэ.



1.3 ТБҮЦ нь 1 хүртэл жилийн хугацаатай, бүртгэлийн хэлбэртэй, нэг бүр нь 1,000,000 (нэг сая) төгрөгийн нэрлэсэн үнэтэй байна.

1.4 ТБҮЦ-нд активын эрсдэлийн сан байгуулахгүй.

1.5 ТБҮЦ-ны арилжаанд дараах шаардлагыг хангасан банк оролцож болно:

1.5.1 Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй, “Төв банкны үнэт цаасны цахим арилжааны ерөнхий гэрээ”-нд нэгдэн орсон;

1.5.2 ~~Монголбанкнаас тогтоох заавал байлгах нооцийн шаардлагыг сүүлийн 3 сарын турш хангаж ажилласан;~~

*МБЕ-ийн 2013 оны 6 сарын 11-ний өдрийн А-118 дугаар тушаалаар хүчингүй.*

1.5.3 Төлбөр тооцооны системд аливаа зөрчил гаргаагүй;

1.5.4 Тухайн банкны худалдан авах ТБҮЦ-ны хэмжээ нь тухайн банкны Монголбанкн дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдлээс “Заавал байлгах нөөц тооцож, хяналт тавих журам”-ын дагуу өдрөөр хангах ЗБН-ийн хэмжээг хасч, тухайн банкинд буцаж буй ТБҮЦ-ны хэмжээг нэмсэнтэй тэнцүү байна. Энэ нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ:

$$S_t^{CBB} = (R_t - \alpha \cdot RR_t) + CBB_t$$

Энд:

$S_t^{CBB}$  – тухайн банкны худалдаж авах боломжтой ТБҮЦ-ны хэмжээ  
 $R_t$  – Монголбанк дахь тухайн банкны төгрөгийн харилцах дансны үлдэгдэл  
 $\alpha$  – “ЗБН тооцож, хяналт тавих журам”-ын 5-д заасан өдрийн хангалтын хувь  
 $RR_t$  – тухайн банкинд тогтоосон ЗБН,  $CBB_t$  – тухайн банкинд буцаж буй ТБҮЦ.

1.6 ТБҮЦ-ыг дараах хэлбэрээр арилжаалж болно:

1.6.1 Монголбанкнаас гаргасан үнэт цаасыг банкинд худалдан борлуулах анхдагч захын үйл ажиллагаа;

1.6.2 Төлөгдөх хугацаа нь болоогүй эзэмшиж буй үнэт цаасыг банкууд өөр хоорондоо худалдах, худалдан авах, репо нөхцөлөөр худалдах, худалдан авах, Монголбанкнаас банкинд репо хэлцэл хийх замаар санхүүжилт олгох хоёрдогч захын үйл ажиллагаа.

### **ХОЁР. ТБҮЦ-ны анхдагч захын арилжааг зохион байгуулах**

2.1 ТБҮЦ-ны арилжааг тогтмол хүүтэй, эсвэл хүүгээр өрсөлдөх гэсэн хоёр хэлбэрээр явуулж болно. Тогтмол хүүтэй арилжаа нь хэмжээг хязгаарлаагүй, эсвэл хязгаарласан хэлбэртэй байж болно.

*/Энэ хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдийн А-79 дүгээр тушаалаар хасав/*

2.2 ТБҮЦ-ны арилжааг дараах хэлбэрээр явуулж болох бөгөөд ТБҮЦ-ны арилжааны мэдэгдлээр арилжааны хэлбэрийг зарлана:

2.2.1 Тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй арилжаа;

2.2.2 Тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарласан арилжаа;

2.2.3 Тодорхой интервалд хүүгээр өрсөлдөх арилжаа;

2.2.4 Хүүгийн дээд хязгаартай, хэмжээ зарлаагүй арилжаа;

2.2.5 Хүүгээр өрсөлдөх, хэмжээ хязгаарласан арилжаа.

*/Энэ хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдийн А-79 дүгээр тушаалаар өөрчлөн найруулав./*

~~2.3 Энэ журмын 2.2-т зааснаас бусад ТБҮЦ-ны арилжааг хүүгээр өрсөлдөх зарчмаар явуулна.~~

*/Энэ хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдийн А-79 дүгээр тушаалаар хасав./*

2.4 Энэ журмын 2.2.1, 2.2.2-т заасан арилжааны хувьд нэрлэсэн үнэ, хямдруулсан үнийн зөрүүгээр тодорхойлогдох өгөөжийн хувь нь Монголбанкны Бодлогын хүүтэй тэнцүү байна. Энэ журмын 2.2.3-т заасан арилжаанд хэрэглэх хүүгийн интервалийг нэрлэсэн үнэ, хямдруулсан үнийн зөрүүгээр тодорхойлогдох өгөөж буюу бодлогын хүүнээс тэгш хэмтэйгээр байгуулна. Бодлогын хүү, хүүгийн интервалын хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална. Энэ журмын 2.2.4-т заасан арилжааны хувьд нэрлэсэн үнэ, хямдруулсан үнийн зөрүүгээр тодорхойлогдох Монголбанкнаас зарласан өгөөжийн дээд хязгаар нь Бодлогын хүүтэй тэнцүү байна.

2.5 ТБҮЦ-ны эргэн төлөгдөх өдөр нь нийтээр амрах баярын өдөр байвал уг өдрийн өмнөх ажлын өдөр төлөгдөхөөр арилжааг зарлана.

2.6 Энэ журмын 2.5-д заасан тохиолдол үүсч долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг 5-аас 9 хоногийн хугацаатай гаргавал, уг арилжааг долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ны арилжаатай ижил зарчмаар явуулна.

~~2.7 Монголбанкны Монгоний бодлого, судалгааны газар (цаашид МБСГ гэх) монгоний бодлогын зорилго, “Макро эдийн засаг, банк, санхүүгийн системийн үзүүлэлтүүд” (1-А дугаар Хавералт) ийн одоо болон ойрын ирээдүйн оорчлогдох хандлага, “Төв банкны нооцийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал” (1Б дүгээр Хавералт) -ыг үндэслэн ТБҮЦ-ны хугацаа, арилжааны хэлбэр, арилжааны хэмжээг хязгаарлах тухай саналыг~~

~~Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж, арилжааны мэдэгдлийг Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулна.~~

Мөнгөний бодлогын зорилго, “Марко эдийн засаг, банк, санхүүгийн системийн үзүүлэлтүүд” (1А дугаар хавсралт)-ийн одоо болон ойрын ирээдүйн өөрчлөгдөх хандлага, “Төв банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал” (1Б дүгээр хавсралт)-ыг үндэслэн ТБҮЦ-ны хугацаа, арилжааны хэлбэр, арилжааны хэмжээг хязгаарлах саналыг Монголбанкны ерөнхий эдийн засагч (цаашид ЕЭЗ гэх), Мөнгөний бодлого, судалгааны газар (цаашид МБСГ гэх)-ын захирал, Валют эдийн засгийн газар (цаашид ВЭЗГ гэх)-ын захирал нар зөвшилцөн, Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж, арилжааны мэдэгдлийг Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулна.

*МБЕ-ийн 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А-117 дугаар тушаалаар өөрчлөн найруулав.*

2.8 Тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй арилжааг дараах зарчмаар явуулна:

2.8.1 ТБҮЦ-ыг гаргах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан арилжааны мэдэгдлийг энэ журмын 2 дугаар Хавсралтын дагуу 9:30 цагт багтаан Банк хоорондын цахим арилжааны систем (БХЦАС)-ээр банкуудад хүргүүлнэ.

2.8.2 Монголбанкнаас зарласан хүүгийн түвшинд үнэт цаас худалдан авах саналаа банкууд арилжаа явагдах өдрийн 9:30-11:00 цагийн хооронд БХЦАС-ээр дамжуулан энэ журмын 3 дугаар Хавсралтын дагуу ирүүлнэ.

2.8.3 Банкуудаас ирүүлсэн саналаар ТБҮЦ-ны арилжааны хуваарилалтыг хийнэ.

2.9 Тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарласан арилжааг дараах зарчмаар явуулна:

2.9.1 ТБҮЦ-ыг гаргах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан арилжааны мэдэгдлийг энэ журмын 4 дүгээр Хавсралтын дагуу 9:30 цагт багтаан БХЦАС-ээр банкуудад хүргүүлнэ.

2.9.2 Монголбанкнаас зарласан хүүгийн түвшинд үнэт цаас худалдан авах саналаа банкууд арилжаа явагдах өдрийн 9:30-11:00 цагийн хооронд БХЦАС-ээр дамжуулан ирүүлнэ.

2.9.3 Тухайн банкны үнэт цаас худалдан авах санал нь ТБҮЦ-ны зарласан нийт хэмжээнээс хэтрэхгүй байна.

2.9.4 Банкуудын ирүүлсэн нийт санал ТБҮЦ-ны зарласан хэмжээнээс хэтрээгүй бол ТБҮЦ-ны арилжааны хуваарилалтыг банкуудын ирүүлсэн саналаар хийнэ. Банкуудын ирүүлсэн нийт санал ТБҮЦ-ны зарласан хэмжээнээс их тохиолдолд хувь тэнцүүлэн хуваарилна.

2.9.5 Хувь тэнцүүлэн хийх хуваарилалтыг дараах томъёогоор тооцно:

$$P = B * \frac{V2}{V1}$$

*P - Тухайн банкинд хуваарилах хэмжээ*  
*V1 - Банкуудын ирүүлсэн нийт саналын хэмжээ*  
*V2 - Тухайн банкны ирүүлсэн саналын хэмжээ*  
*B - Зарласан нийт хэмжээ*

2.10 **ТБҮЦ-ны хүүгээр өрсөлдөх арилжааг** дараах зарчмаар явуулна:

2.10.1 ~~Арилжаа явагдахаас өмнөх ажлын өдөр Монголбанкны МБСГ “Төв банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал” (1Б Хавсралт)-ыг хийж ТБҮЦ гаргах хугацаа, хэмжээний талаарх саналыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулна.~~

**Арилжаа явагдахаас өмнө Монголбанкны МБСГ “Төв банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал” (1Б хавсралт)-ыг хийж ТБҮЦ гаргах хугацаа, хэмжээний талаарх саналыг Монголбанкны ЕЭЗ, МБСГ-ын захирал, ВЭЗГ-ын захирал нар зөвшилцөн Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулна.**

*МБЕ-ийн 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А-117 дугаар тушаалаар өөрчлөн найруулав.*

2.10.2 ТБҮЦ-ны арилжааг хариуцан явуулах Монголбанкны холбогдох газар ТБҮЦ-ыг гаргах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан арилжааны мэдэгдлийг БХЦАС-ээр дамжуулан энэ журмын 5 дугаар Хавсралтын дагуу тухайн өдрийн 9:30 цагт багтаан банкуудад мэдэгдэнэ.

2.10.3 Банк ТБҮЦ-ыг худалдан авах хэмжээ болон хүүгийн саналаа арилжаа явагдах өдрийн 9:30-11:00 цагийн хооронд БХЦАС-ээр дамжуулан ирүүлнэ.

2.10.4 Банк ТБҮЦ-ны арилжаанд хүүгийн саналыг зуутын нарийвчлалаар ирүүлнэ.

2.10.5 Банк ТБҮЦ-ны арилжаанд хүүгээрээ ялгаатай 3 хүртэл санал ирүүлж болно. Уг 3 саналын нийлбэр дүн нь тухайн банкны нийт саналын дүнтэй тэнцүү байна.

2.10.6 Монголбанк банкуудаас ирүүлсэн хүүгийн саналыг өсөх дарааллаар жагсаан хамгийн бага хүүгийн саналаас эхэлж гаргасан үнэт цаасыг дуустал хуваарилалтыг хийнэ. Хэд хэдэн банк ижил хүүгийн санал ирүүлсэн бөгөөд банкуудын ирүүлсэн нийт саналын хэмжээ нийт гаргасан хэмжээнээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэн буюу энэ журмын 2.9.5-д заасан томъёогоор хуваарилалтыг хийнэ.

2.11 Банк саналаа БХЦАС-д оруулж баталгаажуулсан тохиолдолд уг саналыг өөрчлөх, цуцлах эрхгүй.

2.12 Хүүгээр өрсөлдөх арилжаанд банкуудаас ирүүлсэн хүүгийн саналыг Монголбанк шударга бус, хуйвалдсан гэж үзвэл ТБҮЦ-ны тухайн арилжааг цуцлах эрхтэй.

2.13 Давагдашгүй хүчин зүйлсийн болон цахим арилжааны системд эвдрэл гарсны улмаас ТБҮЦ-ны арилжаа 11:00 цагт явагдах боломжгүй тохиолдолд Монголбанк арилжаа хийх хугацааг сунгаж болно. Ингэхдээ банкуудад БХЦАС-ээр дамжуулан, эсвэл утсаар мэдэгдэнэ.



- 2.14 ТБҮЦ-ны арилжааг хариуцан явуулах Монголбанкны холбогдох газар арилжаа явагдсан өдрийн 12:00 цагт багтаан Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх)-т энэ журмын 7 дугаар Хавсралтын дагуу БХЦАС-ээр гүйлгээний шийдвэрийг дамжуулсанаар гүйлгээ хийгдэнэ.
- 2.15 Хямдруулсан хэлбэрээр банкуудад арилжаалах ТБҮЦ-ны хямдруулсан үнийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.
- 2.16 ТБҮЦ-ны өгөөжийг дараах томъёогоор тооцно:

$$i = \frac{F - P}{P} * \frac{365}{t}$$

ТБҮЦ-ны өгөөжид суурилсан хямдруулсан үнийг дараах томъёогоор тооцно:

$$P = \frac{F}{\left[1 + i * \left(\frac{t}{365}\right)\right]}$$

$i$  = Үнэт цаасны төлөгдөх өдөр хүртэлх  $t$  хугацааны өгөөжийн хувь, жилээр

$t$  = Үнэт цаасыг арилжаалсан өдрөөс төлөгдөх өдөр хүртэлх хугацаа

$F$  = Үнэт цаасны нэрлэсэн үнэ

$P$  = Үнэт цаасны өгөөжид суурилсан хямдруулсан үнэ

[МБЕ-ийн 2014 оны 2 сарын 5-ны өдрийн А-24 дүгээр тушаалаар “хүү тооцох суурь хоногийг 360 байсныг 365” болгож өөрчлөв.](#)

- 2.17 ТБҮЦ-ны нягтлан бодох бүртгэлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан, хүчин төгөлдөр мөрдөж буй “Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журам“-ын дагуу хийнэ.

#### ГУРАВ.ТБҮЦ-ны хоёрдогч захын үйл ажиллагаа

- 3.1 Төлөгдөх хугацаа нь болоогүй өөрийн эзэмшилд байгаа ТБҮЦ-ыг банкууд хоорондоо худалдах, худалдан авах, репо нөхцөлөөр худалдах, худалдан авах хэлцэл хийж болно. Банкуудын хооронд хийж буй репо хэлцлийг “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-гээр зохицуулна.
- 3.2 ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа нь БХЦАС-ээр дамжин хийгдэнэ. Монголбанк ТБҮЦ-ны хоёрдогч зах дээр банкуудын хооронд хийгдэх арилжааг зуучлах зорилгоор оролцоно. Монголбанк зуучилсны шимтгэл авахгүй.
- 3.3 Монголбанк төлөгдөх хугацаа нь болсон ТБҮЦ-ны нэрлэсэн үнийг түүний сүүлчийн эзэмшигчид төлнө.
- 3.4 ТБҮЦ-ыг банкууд хоорондоо худалдсан, барьцаалсанаас үүсч болох аливаа эрсдэлийг Монголбанк хүлээхгүй.
- 3.5 Монголбанк ТБҮЦ-аар репо санхүүжилт олгож болно. ТБҮЦ-ны репо санхүүжилтийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан, хүчин төгөлдөр мөрдөж буй

“Төв банкны овернайт репо санхүүжилтийн журам”, “Төв банкны репо арилжааны журам”, “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээ”-гээр тус тус зохицуулна

“Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-ын  
1А дугаар хавсралт

Батлав.ЕРӨНХИЙЛӨГЧ  
dd/mm/yyyy

**ТБҮЦ НЫ АРИЛЖААНЫ САНАЛ**

1	ТБҮЦ ны хүүгийн дээд хязгаар	xx хувь
2	ТБҮЦ ны хүүгийн доод хязгаар	xx хувь
3	ТБҮЦ гаргах хэмжээний дээд хязгаар (ширхэгээр)	xxx
4	ТБҮЦ гаргах хэмжээний доод хязгаар (ширхэгээр)	xxx
5	Хугацаа	xx хоног

.....

..... газрын захирал

.....

**МАКРО ЭДИЙН ЗАСАГ, БАНК, САНХҮҮГИЙН СИСТЕМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД  
/НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ/**

	Үзүүлэлт	Хэмжээ	
		Улаанбаатар	Улсын хэмжээнд
1	Инфляци: xx p сар Сарын оорчлолт Оны эхнээс оорчлолт Жилийн оорчлолт		
2	Ханшийн оорчлолт: xx p сар Сарын Оны эхнээс Жилийн		
3	Монгоний агрегатуудын оорчлолт: Нийт монго: xx p сар Сарын Оны эхнээс Жилийн Бага монго: Сарын Оны эхнээс Жилийн		
4	Эдийн засгийн осолт: xxxx оны гүйцэтгэл		
5	Банк хоорондын захын хүү: xx p сар Сарын оорчлолт Жилийн оорчлолт		
6	Банкуудын хадгаламжийн хүү: xx p сар Сарын оорчлолт Жилийн оорчлолт		

7	Банкуудын зээлийн хүү: хх-р сар Сарын өөрчлөлт Жилийн өөрчлөлт	
---	--	--

Батлав. ЕРӨНХИЙЛӨГЧ  
dd/mm/yyuu

.....

### ТБҮЦ-НЫ АРИЛЖААНЫ САНАЛ

1	ТБҮЦ-ны хүүгийн дээд хязгаар	хх хувь
2	ТБҮЦ-ны хүүгийн доод хязгаар	хх хувь
3	ТБҮЦ гаргах хэмжээний дээд хязгаар (ширхэгээр)	xxx
4	ТБҮЦ гаргах хэмжээний доод хязгаар (ширхэгээр)	xxx
5	Хугацаа	хх хоног

Монголбанкны Ерөнхий эдийн засагч

.....

Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал

.....

Валют, эдийн засгийн газрын захирал

.....

### МАКРО ЭДИЙН ЗАСАГ, БАНК, САНХҮҮГИЙН СИСТЕМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД /нэмэлт мэдээлэл/

	Үзүүлэлт	Хэмжээ	
		Улаанбаатар	Улсын хэмжээнд
1	Инфляци: хх-р сар Сарын өөрчлөлт Оны эхнээс өөрчлөлт Жилийн өөрчлөлт		
2	Ханшийн өөрчлөлт: хх-р сар Сарын Оны эхнээс Жилийн		
3	Мөнгөний агрегатуудын өөрчлөлт: Нийт мөнгө: хх-р сар Сарын Оны эхнээс Жилийн Бага мөнгө: Сарын Оны эхнээс Жилийн		
4	Эдийн засгийн өсөлт: хххх оны гүйцэтгэл		
5	Банк хоорондын захын хүү: хх-р сар Сарын өөрчлөлт Жилийн өөрчлөлт		
6	Банкуудын хадгаламжийн хүү: хх-р сар Сарын өөрчлөлт Жилийн өөрчлөлт		
7	Банкуудын зээлийн хүү: хх-р сар Сарын өөрчлөлт Жилийн өөрчлөлт		

“Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-ын  
1Б дүгээр Хавсралт

			Дундаж уууу.mm.dd- mm.dd
<b>1</b>	<b>Төв банкны бус нийлүүлэлт</b>	<b>(а+б+в+в*)</b>	<b>xxx</b>
<b>а</b>	<b>Гүйлгээнд байгаа мөнгөний өөрчлөлт</b>		xxx
<b>б</b>	<b>Гадаад цэвэр активын өөрчлөлт</b>		xxx
	<i>Ам.доллар худалдах (-)</i>		xxx
	<i>Ам.доллар худалдан авах (+)</i>		xxx
	<i>Төгрөгийн форвард хэлцэл (-)</i>		xxx
	<i>Ам.долларын форвард хэлцэл. (+)</i>		xxx
<b>в</b>	<b>Засгийн газрын цэвэр зээлийн өөрчлөлт</b>		xxx
	<i>Орлого (-)</i>		xxx
	<i>Зарлага (+)</i>		xxx
	<i>ЗГҮЦ/Бондын хугацаа дуусах (+)</i>		xxx
	<i>ЗГҮЦ/Бонд шинээр гаргах (-)</i>		xxx
<b>в*</b>	<b>Бусад санхүүгийн байгууллагын хөрөнгийн өөрчлөлт</b>		xxx
	<i>Орлого (-)</i>		xxx
	<i>Зарлага (+)</i>		xxx
<b>2</b>	<b>Төгрөгийн хүлээгдэж буй бэлэн нөөц /эхний үлдэгдэл/</b>		xxx
<b>3</b>	<b>Төгрөгийн нөөцийн эрэлт</b>	<b>(г+д)</b>	<b>xxx</b>
<b>г</b>	<b>ЗБН-ийн эрэлт</b>		xxx
<b>д</b>	<b>Илүүдэл нөөцийн эрэлт</b>		xxx
<b>4</b>	<b>Нөөцийн эрэлтээс давсан төгрөгийн нөөц /Төв банк нөөц нийлүүлнэ (-), Төв банк нөөц татна (+)/</b>	<b>(2-3)</b>	<b>xxx</b>
<b>5</b>	<b>Төв банкны нөөцийн нийлүүлэлт (+), нөөцийн таталт (-)</b>	<b>(е+ё+ж+з+ +и+й+к)</b>	<b>xxx</b>
<b>е</b>	<b>Овернаит репо санхүүжилт</b>		xxx
	<i>буцах (-)</i>		xxx
	<i>олгох (+)</i>		xxx
<b>ё</b>	<b>Овернаит хадгаламж</b>		xxx
	<i>буцах (+)</i>		xxx
	<i>олгох (-)</i>		xxx
<b>ж</b>	<b>Репо арилжаагаар олгосон санхүүжилт</b>		xxx
	<i>буцах (-)</i>		xxx
	<i>олгох (+)</i>		xxx
<b>з</b>	<b>Ам.долларын своп</b>		xxx
	<i>буцах (-)</i>		xxx
	<i>олгох (+)</i>		xxx
<b>и</b>	<b>Төгрөгийн своп</b>		xxx
	<i>буцах (+)</i>		xxx
	<i>олгох (-)</i>		xxx
<b>й</b>	<b>Барьцаат зээл</b>		xxx
	<i>буцах (-)</i>		xxx
	<i>олгох (+)</i>		xxx
<b>к</b>	<b>Бусад санхүүжилт</b>		xxx
	<i>буцах (-)</i>		xxx
	<i>олгох (+)</i>		xxx
<b>6</b>	<b>ТБҮЦ-ны өөрчлөлт /(+) бол ТБҮЦ-ыг нэмэгдүүлэх, (-) бол ТБҮЦ-ыг бууруулах/</b>	<b>(л+м)</b>	<b>xxx</b>
<b>л</b>	<b>1 долоо хоногтой ТБҮЦ-ны өөрчлөлт</b>		xxx

	<i>Шинээр гаргах (*)</i>		xxx
	<i>Буцах</i>		xxx
<b>м</b>	<b>4 долоо хоногтой ТБҮЦ-ны өөрчлөлт</b>		xxx
	<i>Шинээр гаргах (*)</i>		xxx
	<i>Буцах</i>		xxx
<b>7</b>	<i>Төв банкны цэвэр санхүүжилт</i>	<i>(5-6)</i>	xxx
<b>8</b>	<i>Төгрөгийн хүлээгдэж буй бэлэн нөөц /эцсийн үлдэгдэл/</i>	<i>(2+7)</i>	xxx
<b>9</b>	<i>Эцсийн позици</i>	<i>(4+7)</i>	Xxx

“Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-ын  
2 дугаар хавсралт

### ТБҮЦ-НЫ АРИЛЖААНЫ МЭДЭГДЭЛ

... оны ... сарын ... өдөр

Арилжааны дугаар ...

Төв банкны үнэт цаасны тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй арилжааг ... оны ... сарын ... -  
ний өдөр явуулах болсныг мэдэгдье.

Хугацаа: ... хоног

Гүйлгээ хийх өдөр: ... оны ... сарын ...

Төлөгдөх хугацаа: ... оны ... сарын ... өдөр

Хямдруулалтын хувь хэмжээ: ... хувь

Нэрлэсэн үнэ: ... төгрөг

\_\_\_\_\_

**ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД  
ОРОЛЦОХ САНАЛЫН ХУУДАС**

Банкны нэр: .....

Арилжааны дугаар: ...

Хугацаа: ... хоног

Гүйлгээ хийх өдөр: ... оны ... сарын ...

Төлөгдөх хугацаа: ... оны ... сарын ... өдөр

Худалдан авах үнэт цаасны хэмжээ: ... ширхэг

Худалдан авах үнэт цаасны нэрлэсэн үнэ: ... төгрөг

Банкийг төлөөлөх эрх бүхий ажилтны гарын үсэг: ..... (гарын үсгийн тайлал)  
(тамга)

Санал хүлээн авсан Монголбанкны ажилтан: ..... (гарын үсгийн тайлал)

Санал хүлээн авсан цаг минут:

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

## МЭДЭГДЭЛ

... оны ... сарын ...

Арилжааны дугаар ...

Төв банкны үнэт цаасны тогтмол хүүтэй, хэмжээг хязгаарласан арилжааг ... оны ... сарын ... -  
ний өдөр явуулах болсныг мэдэгдье.

Арилжаалах үнэт цаасны хэмжээ: ... төгрөг

Хугацаа: ... хоног

Гүйлгээ хийх өдөр: ... оны ... сарын ...

Төлөгдөх хугацаа: ... оны ... сарын ... өдөр

Хямдруулалтын хувь хэмжээ: ... хувь

Нэрлэсэн үнэ: ... төгрөг

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



### МЭДЭГДЭЛ

... оны ... сарын ...

Арилжааны дугаар ...

Төв банкны үнэт цаасны хүүгээр өрсөлдөх арилжааг ... оны ... сарын ... -ний өдөр хүүгээр өрсөлдүүлэх зарчмаар явуулах болсныг мэдэгдье.

Арилжаалах үнэт цаасны хэмжээ: ... төгрөг

Хугацаа: ... хоног

Гүйлгээ хийх өдөр: ... оны ... сарын ...

Төлөгдөх хугацаа: ... оны ... сарын ... өдөр

Нэрлэсэн үнэ: ... төгрөг

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

**ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД  
ОРОЛЦОХ САНАЛЫН ХУУДАС**

Банкны нэр: .....

Арилжааны дугаар: ...

Хугацаа: ... хоног

Гүйлгээ хийх өдөр: ... оны ... сарын ...

Төлөгдөх хугацаа: ... оны ... сарын ...

	Хямдруулалтын хувь хэмжээ	Ширхэг	Хямдруулсан үнэ	Нэрлэсэн үнэ
1				
2				
Нийт				

Банкийг төлөөлөх эрх бүхий ажилтны гарын үсэг: ..... (гарын үсгийн тайлал)  
(тамга)

Санал хүлээн авсан Монголбанкны ажилтан: ..... (гарын үсгийн тайлал)

Санал хүлээн авсан цаг минут:

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

### ГҮЙЛГЭЭНИЙ ШИЙДВЭР

ТТБГ-т

ГҮЙЛГЭЭНИЙ УТГА:

Нэг бүр нь 1 000 000 (нэг сая) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ...  
хоногийн хугацаатай ТБҮЦ-ны ... тоот арилжааны гүйлгээг  
дараах нөхцөлийн дагуу хийх. Үүнд:

	Банкны нэр	Хямдруулалтын хувь хэмжээ (%)	Нэгжийн үнэ	Нэгжийн хямдруулалт	Ширхэг	Худалдах үнэ (₮)	Хямдруулалт	Буцаан худалдан авах үнэ (₮)
1								
2								
...								
	Дүн							

Гүйлгээ хийх өдөр: ...

Үнэт цаас төлөгдөх өдөр: ...

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

### ГҮЙЛГЭЭНИЙ ШИЙДВЭР

ТТБГ-т

ГҮЙЛГЭЭНИЙ УТГА:

Нэг бүр нь 1 000 000 (нэг сая) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ...  
хоногийн хугацаатай ТБҮЦ-ны ... тоот арилжааны гүйлгээг  
дараах нөхцөлийн дагуу хийх. Үүнд:

	Банкны нэр	Хямдруулалтын хувь хэмжээ (%)	Нэгжийн үнэ	Нэгжийн хямдруулалт	Ширхэг	Худалдах үнэ (₮)	Хямдруулалт	Буцаан худалдан авах үнэ (₮)
1								
2								
...								
	Дүн							

Гүйлгээ хийх өдөр: ...

Үнэт цаас төлөгдөх өдөр: ...

ВЭЗГ-ын эдийн засагч

.....

**Монголбанкны Ерөнхий эдийн засагч**  
**МБСГ-ын захирал**  
**ВЭЗГ-ын захирал**

.....  
.....  
.....

*МБЕ-ийн 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А-117 дугаар тушаалаар өөрчлөв.*

